

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 9 дүгээр сарын
17-ны өдөр

Дугаар 303/126

Улаанбаатар хот

“Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх,
хянах Үндэсний стратеги” батлах тухай

ДЭМБ-ын “Хөгжиж буй орнуудад зайлсхийж болох дүлийрэлт, сонсгол бууралтыг багасгах хамтын ажиллагааны хөтөлбөр”, Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах Үндэсний стратеги”-ийг нэгдүгээр, стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Орон нутгийн онцлогт тохируулан Үндэсний стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг энэ оны 4 дүгээр улиралд багтаан боловсруулж батлан хэрэгжүүлэхийг, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Үндэсний стратегийн хэрэгжилтийн явц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг жил бүрийн 2 дугаар улиралд багтаан Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Удирдлагын зөвлөлийн хамтарсан хуралд танилцуулж байх, стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан хэрэгжилтийг зохицуулж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Төгсдэлгэр/, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ш.Энхбат/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Энхтуяа/, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар /Д.Баярсайхан/-т даалгасугай.

4. Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд Олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлэх, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Н.Түмэндэмбэрэл/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Х.Мөнхзул/-т үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Хүрэлбаатар/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ш.Мөнхцэрэн/ нарт тус тус даалгасугай.





ДҮЛИЙРЭЛТ, СОНСГОЛ БУУРАЛТААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

(2010-2019)

Нэг. Үндэслэл

Дүлийрэлт, сонсгол бууралт гэдэг нь нэг ба хоёр чихний сонсох үйл ажиллагаа бүрэн үгүй болох доголдохыг илэрхийлсэн ойлголт бөгөөд энэ нь хүний эрүүл амьдрах ба нийгмийн харилцаанд хэвийн оролцох эрхийг хязгаарлаж, улс орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын 2005 оны мэдээгээр сонсголын үйл ажиллагааны хямралтай дэлхийн 278 сая хүний 80% нь буурай хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад амьдарч байна. Дэлхийн хүн ам өсч, урт наслахын хирээр энэ тоо өсөх хандлагатай байна. Дүлийрэлт, сонсгол бууралтад шууд ба дам хүргэдэг шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийг арилгаж урьдчилан сэргийлж чадвал энэ эмгэгийг 50% бууруулах боломжтой гэж судлаачид үздэг. Дүлийрэлт, сонсгол бууралтын дийлэнх хувь нь сонсголд нөлөөт эмийн замбараагүй хэрэглээ, дунд чихний архаг үрэвсэл, дуу шуугианаас шалтгаалдаг байна.

Дүлийрэлт, сонсгол бууралт нь хүнийг тахир дутуу болгож, амьдралын чанарыг нь алдагдуулан нийгмийн харилцаанд томоохон асуудал үүсгэдэг учраас ДЭМБ-ын анхаарлын төвд ямагт байсаар ирсэн юм. ДЭМБ-аас гаргасан “Эмнэлэг-ариун цэврийн анхан шатны тусламжийн деклараци” /Алма-Ата, 1978 / ДЭМБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Маргарет Чений “Дэлхийн эрүүл мэндийн байдлын тухай илтгэл” /2007/ , “Хөгжиж буй орнуудад зайлсхийж болох дүлийрэлт, сонсгол бууралтыг багасгах хамтын ажиллагааны хөтөлбөр” /2006/ зэрэг тухайн асуудлыг шууд болон дам хөндсөн баримтуудыг дурьдаж болно.

Манай орны хувьд ойролцоогоор 190-ээд мянган сонсголын бууралттай ба дүлий хүн байдаг, Улаанбаатар хотын нийт хүн амын 0,4%, хөдөөгийн нийт хүн амын 0,7% нь дунд чихний наалдаст үрэвслийн улмаас дүлийрэлтэй байна /Л.Шагдар, 1993/ гэсэн судалгаа байдаг. Гэсэн ч нарийвчилсан судалгаа үгүй, ялангуяа хүүхдийн дүлийрлийн асуудлыг эмнэлзүйн хүрээнд шийдвэрлэсэн цөөн тооны судалгаа шинжилгээний ажлууд хийгдсэн боловч тархалтын тандалт, судалгааны асуудал өмнө нь хөндөгдөж байгаагүй болно.

Эрүүл мэндийн статистик мэдээллээр 10 000 хүн амд ногдох дүлийрэлт 2000 онд 3.89 байсан бол 2008 онд 7.56 болж 2 дахин нэмэгджээ.

Хоёр.Тулгамдсан асуудлууд

- Манай орны хувьд дүлийрэлт, сонсгол бууралтын тархалт, нөлөөлөгч хүчин зүйлсийг нарийвчлан тогтоох тандалт судалгаа сүүлийн жилүүдэд улсын хэмжээний хийгдээгүй;
- Сонсголын тусламж үйлчилгээг найдвартай хянах, үнэлэх чадавхи бүхий мэдээлэл харилцаа, удирдлага, хяналтын тогтолцоо хараахан бүрдээгүй;
- Сонсголоо хамгаалах талаар иргэдийн мэдлэг, хандлага муу;
- Сонсгол судлах, засах, эмчлэх, нөхөн сэргээх үйлчилгээ бүх хүн амыг хамарч чадаагүй;
- Сонсгол хамгаалах үйл ажиллагааг дэмжих орчин бүрдээгүй;
- Сонсгол судлал, заслын эмч, мэргэжилтэн дутагдалтай;
- Мэргэжлийн байгууллагуудын тоног төхөөрөмж, эм хэрэгслийн хангамж муу;
- Санхүүжилт хангалтгүй.

Гурав. Үндэсний стратегийн зорилго

Хүн амын дунд дүлийрэлт, сонсгол бууралтын тархалтын түвшинг тогтоон 2019 онд тогтоогдсон түвшингээс 5 хувиар бууруулна.

Дөрөв. Үндэсний стратеги хэрэгжих хугацаа, зарчим, санхүүжилт

4.1. Үндэсний стратегийг 2010-2019 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1-р үе шат нь 2010-2014 онд

2-р үе шат нь 2015-2019 онд

4.2. Үндэсний стратегийн хэрэгжилтэд дараахь зарчмыг баримтална:

4.2.1. Баримт нотолгоонд тулгуурласан үйл ажиллагаа явуулах;

4.2.2. Үндэсний стратегийн хэрэгжилтэд байгаа нөөц боломжийг дайчлах;

4.2.3. Чих, сонсголын тусламжийг эрүүл мэндийн тусламжийн бүх шатлалд хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;

4.2.4. Мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах;

4.2.5. Сонсгол бууралттай болон дүлий хүмүүст үзүүлэх нөхөн сэргээх, нийгмийн халамжийн үйлчилгээг хүртээмжтэй болгох.

4.3. Үндэсний стратегийн хэрэгжилтийг хөрөнгийн дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

а) улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

- б) Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө;
- в) олон улсын байгууллага, хандивлагч орнуудын хандив тусламж;
- г) гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж; иргэдийн хандив, санхүүгийн дэмжлэг тусламж;
- д) хууль, тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр.

Тав. Үндэсний стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэл

5.1. Стратегийн нэгдүгээр зорилт

Дүлийрэлт, сонсгол бууралтад хүргэдэг хүчин зүйлсийн тархалтыг тогтоож урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авч сонсгол хамгаалах үйл ажиллагааг дэмжих орчин бүрдүүлнэ.

5.1.1. Стратегийн нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1/ Дүлийрэлт, сонсгол бууралтын эрсдэлт хүчин зүйлсийн тархварзүйн судалгааг хийж, нотолгоонд тулгуурласан бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2/ Сонсгол бууралт, дүлийрэлтийн талаар иргэд, эцэг, эхчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, энэхүү үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн бүх хэрэгслийг ашиглах;

3/ Улаанууд(цитомегаловирус)-ын эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх;

4/ Жирэмсэн эмэгтэйчүүдийг тэмбүү болон бэлгийн замын бусад халдварын шинжилгээнд бүрэн хамруулж, халдвар илэрсэн тохиолдолд эмчилж эдгэрүүлэх арга хэмжээг хүртээмжтэй болгох;

5/ Жирэмсэн ба перинаталь үеийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмжийг сайжруулах, дүлийрэлт, сонсгол бууралтыг нярай үед нь эрт илрүүлэх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад тогтмол хамруулах;

6/ Хүүхдийн халдварт өвчнүүд (улаан бурхан, менингит, улаанууд, гахай хавдар)-ийн эсрэг дархлаажуулалтын арга хэмжээг товллын дагуу чанартай хийх;

7/ Сонсголд нөлөөтэй нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийг сонсгол хамгаалах хэрэгслээр хангах, ажиллагсдыг ажлын байрны шуугианаас шалтгаалсан дүлийрэлт, сонсгол бууралтаас хамгаалах талаар ажил олгогчдын хүлээх үүрэг, хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид тусгах, хэрэгжүүлэх;

8/ Сонсгол бууралттай болон дүлий хүмүүст эмчилгээ үйлчилгээний болон сонсголын аппарат бусад тоноглолын зардлыг санхүүжүүлэх асуудлыг Нийгмийн даатгал болон Нийгмийн халамжийн хуулиудад тусгаж шийдвэрлэх ;

9/ Сонсголд нөлөөт эм, бэлдмэлийг зөвхөн мэргэжлийн эмчийн жороор олгож, хяналттай хэрэглэх механизмыг бүрдүүлэх, сонсголд нөлөөт эм, бэлдмэлийн хангамж, хэрэглээтэй холбоотой стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих;

10/ Дуу шуугиантай ажлын байр, олон нийтийн зугаа цэнгээний газруудад шуугианы хүчийг хэмжих, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох ажлыг зохион байгуулах;

11/ Дуу шуугианаас хамгаалах олон улсын стандартыг хэрэгжүүлэх, үндэсний болгох;

12/ Стратегийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авах.

5.2. Стратегийн хоёрдугаар зорилт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд сонсголын тусламж, үйлчилгээг найдвартай үзүүлэх сүлжээг бий болгож, дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн мэргэжлийн байгууллагын чадамжийг сайжруулна.

5.2.1. Стратегийн хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1/ Дунд чихний цочмог, архаг, шүүдэст, наалдаст үрэвслийн оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж боловсруулж улсын хэмжээнд мөрдүүлэх;

2/ Чих, сонсголын анхан шатны тусламжийн зайлшгүй шаардлагатай эм бэлдмэл, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг эрүүл мэндийн тусламжийн бүх шатлалд сайжруулж шинэчлэх;

3/ Дунд чихний хурц, архаг, шүүдэст, наалдаст үрэвсэл, сонсох мэдрэлийн үрэвсэл, шуугианы гаралтай дүлийрэлтийн талаар эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сургалт явуулах;

4/ Сонсгол засах, эмчлэх, нөхөн сэргээх чиглэлээр гадаад орнуудад эмч мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх;

5/ Өөрийн орны онцлогт тохирсон оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн байнгын болон явуулын тусламжийг зохион байгуулах;

6/ Дүлий, сонсгол бууралттай хүмүүсийн нийгмийн халамжийг сайжруулж, эмчилгээ үйлчилгээг даатгалд хамааруулах механизмыг бүрдүүлэх;

7/ Дүлий, пайтан хүүхдэд зориулсан сургалтыг олон улсын жишгээр боловсронгуй болгох;

8/ Дүлийрэлт, сонсгол бууралтаас хамгаалах, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эм, хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг импортлох үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

9/ Сонсгол бууралт, чихний эмгэгийн эмчилгээнд хэрэглэж байгаа эм бэлдмэл, сонсголын аппарат, эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт тавих.

Зургаа. Үндэсний стратегийг хэрэгжүүлэгч талууд:

6.1. Үндэсний стратегийн хэрэгжилтийг удирдлага, төлөвлөлтөөр ханган хэрэгжилтийн явц, үр дүнг хянах, тайлагнах асуудлыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд төрийн болон хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэх бөгөөд эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Стратегийн хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий Удирдах зөвлөл (цаашид Зөвлөл гэнэ)-ийг байгуулна.

6.1.1. Зөвлөл нь эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамж, үйлдвэр, үйлчилгээ, мэргэжлийн хяналтын зэрэг бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, зөвлөл, чих, сонсгол судлалын болон ерөнхий мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний төлөөлөл оролцсон бүрэлдэхүүнтэй байна.

6.1.2. Зөвлөл нь дүлийрлээс сэргийлэх, хянах үйл ажиллагаанд бусад салбарын оролцоог идэвхижүүлэн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

6.2. Стратегийн хэрэгжилтийг орон нутагт төлөвлөх, удирдан зохион байгуулах, хянах, тайлагнах үүрэг бүхий Орон нутгийн салбар зөвлөл (цаашид Салбар зөвлөл гэнэ)-ийг Эрүүл мэндийн газрын даргын шийдвэрээр байгуулна.

6.2.1. Салбар зөвлөл нь холбогдох төрөлжсөн нарийн мэргэжлийн болон ерөнхий мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамж, үйлдвэр, үйлчилгээ, мэргэжлийн хяналтын байгууллагын болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон бүрэлдэхүүнтэй байна.

6.2.2. Салбар зөвлөл нь орон нутгийн түвшинд зохион байгуулсан арга хэмжээний тайланг Зөвлөлд тайлагнах үүрэг хүлээнэ.

6.3. Энэхүү стратегийг ЭМЯ, НХХЯ, БСШУЯ, СЯ, ГХЯ, ХХААХҮЯ, МХЕГ, Орон нутгийн Засаг дарга түүний Тамгын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн

газар, сум, өрхийн эмнэлэг, клиникийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвүүд, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод болон хэвлэл, мэдээллийн байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ.

6.4. Стратегийн хэрэгжилтэд гадаад орон, олон улсын байгууллага, бусад хандивлагчид болон түншлэгч талууд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

6.5. Стратегийг хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн зөвлөгөөг холбогдох мэргэжлийн агентлагууд хариуцан гүйцэтгэнэ.

Долоо. Үндэсний стратегийн хүрэх үр дүн

Стратегийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ.

7.1. Стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд:

1/ Дүлийрэлт, сонсгол бууралтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг судлан тогтоож баримт нотолгоонд тулгуурласан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна;

2/ Хэт их дуу, шуугианаас сонсгол хамгаалах, эмчлэх, нөхөн сэргээх, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин сайжирна;

3/ Хэт их дуу, шуугианаас сонсголоо хамгаалах, дүлийрэлтээс сэргийлэх талаар олон нийт, шуугиантай орчин ажиллагсадын мэдлэг, дадал нэмэгдсэн байна;

4/ Төрөх насны болон жирэмсэн эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд, хүүхдийг дүлийрэлт, сонсгол бууралтад хүргэдэг халдварт өвчнүүдийн эсрэг дархлаажуулалтад бүрэн хамруулдаг болсон байна;

5/ Дүлийрэлт, сонсгол бууралтыг нярай үед нь эрт илрүүлэх талаар эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтний чадамж сайжирсан байна;

6/ Сонсголд нөлөөт эм, бэлдмэлийн хангамж, хэрэглээнд тавих хяналтын механизмтай болсон байна.

7.2. Стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд:

1/ Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, тэдгээрийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж эрүүл мэндийн тусламжийн бүх шатлалд сайжирсан байна;

2/ Сонсгол бууралттай ба дүлий хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ сайжирч эмчилгээ, үйлчилгээг даатгалд хамруулах механизмтай болсон байна;

3/ Дүлийрэлт, сонсгол бууралтаас хамгаалах, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээхэд шаардлагатай эм, хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг импортлох үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлдэг болж хангамж нь сайжирна;

4/ Сонсголын аппаратын хангамж, тохиргоо, засвар үйлчилгээ сайжирсан байна.

Найм. Стратегийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт:

8.1. Стратегийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг эрүүл мэндийн болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд хариуцан бусад төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран улсын хэмжээнд, орон нутагт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

8.2. Стратегийн хүрээнд тавьсан зорилт, үйл ажиллагаатай уялдуулан дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	2010	2014	2019
		(суурь түвшин)	(дунд хугацаанд)	(хүрэх түвшин)
1	Чих, сонсголын анхан шатны тусламжийн талаарх сургалтад хамрагдсан сум, өрхийн эмч нарын эзлэх хувь	0	50%	100%
2	Чих, сонсголын анхан шатны үзлэгийн багажаар хангагдсан сум, өрхийн эмнэлгийн эзлэх хувь	0	50%	100%
3	Сонсголын аппаратын хүртээмж	10%	40%	80%
4	Дүлийрэлт, сонсгол бууралтад хүргэдэг дунд чихний архаг үрэвслийн тархалт	Түвшинг тогтооно	Тогтоосон түвшингээс 5%-иар буурна.	Тогтоосон түвшингээс 10%-иар буурна.
5	Сонсгол бууралтын тархалт	Түвшинг тогтооно	Тогтоосон түвшингээс 2%-иар буурна.	Тогтоосон түвшингээс 5%-иар буурна.
6	Дүлийрэлтийн тархалт	Түвшинг тогтооно	Тогтоосон түвшингээс 2%-иар буурна.	Тогтоосон түвшингээс 5%-иар буурна.

Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 303/148 тоот хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

**ДҮЛИЙРЭЛТ, СОНСГОЛ БУУРАЛТААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

(2010-2019)

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа	Үр дүн	Шалгуур үзүүлэлт
Зорилт 1. Дүлийрэлт, сонсгол бууралтад хүргэдэг хүчин зүйлийн тархалтыг тогтоож урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авч сонсгол хамгаалах үйл ажиллагааг дэмжих орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд:						
Арга хэмжээ-1. Дүлийрэлт, сонсгол бууралтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг судлах						
1.1	Дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оношилгоо, эмчилгээ, тэдгээрийн үр дүнг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төлөвлөгөө гарган улсын захиалгат эрдэм судлалын ажлын хүрээнд санхүүжүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	ЭМЯ	БСШУЯ, Шинжлэх ухаан технологийн сан	2010-2019	Судалгааны ажлын төлөвлөгөө гарсан байна	Батлагдсан төлөвлөгөө, санхүүжүүлсэн улсын захиалгат эрдэм судлалын ажлын тоо, тэдгээрийн тайлан
1.2	Дүлийрэлт, сонсгол бууралтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн тархалтын түвшин тогтоох суурь судалгаа явуулах	ЭМШУИС	БСШУЯ ЭМЯ, НЭМХ, АУХ, Мэргэжлийн зөвлөл,	2010-2012	Дүлийрэлт, сонсгол бууралтын тархалтын талаар	Судалгааны тайлан

			нийгэмлэг		баримт нотолгоотой болно	
Арга хэмжээ-2. Дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх талаар 3 шатны (хүн ам, ерөнхий мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэн) сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх						
2.1	Дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх, хянах талаар Үндэсний уулзалт, зөвлөлгөөн зохион байгуулах	ЭМЯ	ЭМШУИС Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг ДЭМБ	2010- 2019	Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үйл ажиллагааны байдалд дүгнэлт хийж цаашдын үйл ажиллагааг төлөвлөнө	Семинар, зөвлөлгөөний тайлан
2.2	Дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх, хянах талаар сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэх	ЭМЯ	ЭМШУИС Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг ДЭМБ	2010- 2013	Сургалт явуулах багш нартай болно	Сургагч тоо багшийн
2.3	Дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх талаар гарын авлага бэлтгэх, хэвлэх, тараах	ЭМЯ	ЭМШУИС Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг ДЭМБ	2010- 2010	Чих сонсголын тусламжийн гарын авлагатай болно.	Хэвлэгдсэн гарын авлага
2.4	Дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх талаар анагаах ухаан,	ЭМШУИС	ЭМЯ БСШУЯ Мэргэжлийн	2010- 2012	Төгсөгчид дүлийрэлт, сонсгол	Батлагдсан агуулга, хөтөлбөр

	сүвдэхүйн төгсөлтийн сургалтын тусгах өмнөх болон дараах агуулга, хөтөлбөрт		зөвлөл, нийгэмлэг		бууралтаас урьдчилан сэргийлэх, хянах талаар мэдлэгтэй болно.	
2.5	Сонсгол бууралтыг нярай үед нь эрт илрүүлэх, сонсгол хамгаалах талаар эцэг, эхчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр сургалт, сурталчилгааны материал боловсруулан сургалт явуулах	ЭНЭШТ	ЭМШУИС, Аймаг, нийслэлийн ЭМГ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	2010-2019	Эцэг, эхчүүдийн мэдлэг, дадал дээшилж урьдчилан сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тэдний оролцоо нэмэгдэнэ	Батлагдсан сургалтын хөтөлбөр, гарын авлага, сурталчилгааны материал, Сургалтын тайлан
2.6.	Сонсгол бууралт, дүлийрэлтээс урьдчилан сэргийлэх, сонсгол засах, эмчлэх, нөхөн сэргээх чиглэлээр гадаад орнуудад эмч мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх	ЭМЯ	ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан	2010-2019	Хүний нөөцийн чадавхи сайжирна	Сургалтад хамрагдсан хүний тоо
Арга хэмжээ-3. Сонсгол бууралт, дүлийрэлтийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, баримт нотолгоонд түшиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх						
3.1	Чих, сонсгол судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх (магиср, докторын түвшинд)	ЭМШУИС	ЭМЯ БСШУЯ	2010-2019	Чих сонсгол судлалын чиглэлээр судалгааны ажлууд	Эрдэм шинжилгээний ажлын тайлан

3.2	Чих сонгол судлалын чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх:					хийгдсэн байна.	
	- "Дүлий хүмүүст сонгол сайжруулах иж бүрдэл арга" төсөл	ЭМШУИС ЭМЖЖ эмнэлэг	БСШУЯ ЭМЯ	2010- 2011	Сонгол бууралттай болон дүлий хүмүүсийн сонголыг сайжруулах талаар ахиц гарна		Төсөлт ажлын үр дүн, тайлан
	- "Сонголын суулгацын төв" байгуулах төсөл	"Эйд" эмнэлэг УКТЭ	ЭМЯ ЭМШУИС	2010- 2019			
	- "Хүүхдийн сонгол сайжруулах" төсөл	ЭНЭШТ	ЭМЯ ДЭМБ	2010- 2019			
Арга хэмжээ-4. Төрөх насны болон жирэмсэн эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд, хүүхдийг дүлийрэлт, сонгол бууралтад хүргэдэг халдварт өвчнүүдийн эсрэг дархлаажуулалтад бүрэн хамруулах							
4.1	Хүүхдийг (цитомегаловирус)-ын эсрэг дархлаажуулалтад хамруулах арга хэмжээ авах	ЭМЯ, ХӨСҮТ	ДЭМБ Аймаг, нийслэлийн ЭМГ,	2010 оноос	Цаашдаа төрөх насны эмэгтэйчүүд улаануудын эсрэг дархлаажуу- лалттай болно	Дархлаажуулалтад хамрагдагсдын тоо, хувь	
4.2	Төрөх насны болон жирэмсэн эмэгтэйчүүдийг тэмбүү болон бэлгийн замын бусад халдварын шинжилгээнд бүрэн хамруулж, халдвар илэрсэн тохиолдолд эмчилж эдгэрүүлэх, хяналтад авах арга хэмжээг холбогдох	ЭМЯ ХӨСҮТ	ЭНЭШТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	2009- 2019	Төрөх насны болон жирэмсэн эмэгтэйчүүд үзлэгт хамрагдаж эмчлэгдсэн	Үзлэгт хамрагдсан болон эмчлэгдсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь	

	байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх	ЭМЯ ХӨСҮТ	ЭНЭШТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	2009-2019	байна	Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн тоо, хувь
4.3	Хүүхдийн халдварт өвчнүүд (улаан бурхан, менингит, улаанууд, гахай хавдар)-ийн дархлаажуулалтыг товллын дагуу чанартай хийх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх				Хүүхдүүд халдварт өвчнүүдийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан байна	
Арга хэмжээ-5. Хэт их дуу, шуугианаас сонсгол хамгаалах, нөхөн сэргээх талаарх эрх зүйн орчныг сайжруулах						
5.1	Дуу, шуугианаас хамгаалах олон улсын стандартыг хэрэгжүүлэх, үндэсний болгох арга хэмжээ авах	НХХЯ	СХЗГ, ЭМЯ	2010-2011	Дуу, шуугианаас хамгаалах олон улсын стандартыг үндэсний болгох асуудал шийдвэрлэгдэнэ	Боловсруулж батлагдсан стандарт
5.2	Ажиллагсдыг ажлын байрны шуугианаас шалтгаалсан дүлийрэлт, сонсгол бууралтаас хамгаалах талаар ажил олгогчдын хүлээх үүрэг, хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид тусгах, хэрэгжүүлэх	НХХЯ	ХЗДХЯ, ЭМЯ Ажил олгогч эздийн холбоо, бусад ТББ	2010-2012	Ажиллагсдыг дүлийрэлт, сонсгол бууралтаас хамгаалах үйл ажиллагаа сайжирна	Батлагдсан хууль тогтоомж, түүний хэрэгжилт
5.3	Дуу шуугиантай ажлын байр, олон нийтийн зугаа цэнгээний газруудад шуугианы хүчийг хэмжих, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох	НХХЯ	МХЕГ, СХЗГ	2010-2013	Дуу шуугианы хүлээн зөвшөөрөгдөх хэмжээг	Шуугианы хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээг тогтоосон эрх зүйн баримт

ажлагч баталгаажуулах	ажлааг зохион байгуулж	НХХЯ	ХЗДХЯ, ЭМЯ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	2010- 2014	Хууль эрх зүйн орчин сайжирна	Боловсруулж батлагдсан тогтоомж хууль
5.4.	Сонсгол бууралттай болон дүлий хүмүүсийн эмчилгээ үйлчилгээний болон сонсголын аппарат бусад тоноглолын зардлыг санхүүжүүлэх асуудлыг Нийгмийн даатгал болон Нийгмийн халамжийн хуулиудад тусгаж шийдвэрлэх	НХХЯ	ХЗДХЯ, ЭМЯ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	2010- 2014	Хууль эрх зүйн орчин сайжирна	Боловсруулж батлагдсан тогтоомж хууль
5.5	Дүлийрэлт, сонсгол бууралтаас хамгаалах, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эм, хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг импортлох үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр хамтарсан шийдвэр /журам/ гаргаж хэрэгжүүлэх	ЭМЯ	СЯ, ГХЯ, НХХЯ, ГЕГ	2010- 2013	Татварын хөнгөлөлт үзүүлэх талаар хамтарсан шийдвэр /журам/ гарсан байна.	Хамтарсан шийдвэр /журам/
Арга хэмжээ-6. Хэт их дуу, шуугианаас сонсгол хамгаалах талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх						
6.1	Дүлийрэлт, түүнээс урьдчилан сэргийлэх, сонсгол хамгаалах талаар бүх шатны боловсролын байгууллагуудын сургалтын агуулга, хөтөлбөрт тусгах	БСШУЯ	ЭМЯ	2010- 2012	Сонсгол хамгаалах, дүлийрлээс сэргийлэх талаар бүх шатны боловсролын байгууллагын сургалтын агуулга, хөтөлбөрт туссан байна.	Батлагдсан сургалтын агуулга, хөтөлбөр, хэрэгжүүлсэн байгууллагын тоо
	Хэт их дуу, шуугианаас сонсголоо хамгаалах талаар олон нийтийн	ЭМЯ	БСШУЯ, НХХЯ,	2009- 2019	Олон нийтийн мэдлэг,	Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд

6.2	мэрдэг, хандлагыг дээшлүүлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах	НХХЯ	Хэвлэл мэдээллийн байгууллага		хандлага дээшилнэ	хамрагдсан тоо	хүний
6.3	Шуугиантай ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмын талаар сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагын оролцоотой зохион байгуулах		ЭМЯ, БСШУЯ ТББ	2010-2019	Дуу, шуугиантай орчинд ажиллагсдын мэдлэг, хандлага дээшилнэ	Сургалтад хамрагдсан байгууллага, тоо	хүний
6.4	Байгууллага, хамт олны хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Аж ахуйн нэгж, байгууллага	Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллага	2010-2019	Дүлийрэх, сонсгол муутахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна	Үзлэгт хамрагдсан байгууллага, хамт олны тоо, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	
Зорилт-2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд сонголын тусламж, үйлчилгээг найдвартай үзүүлэх сүлжээг бий болгож, дүлийрэлт, сонсгол бууралтаас урьдчилан сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн мэргэжлийн байгууллагын чадамжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
Арга хэмжээ-7. Сонголын тусламж үзүүлж байгаа мэргэжлийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх							
7.1	Чих, сонголын тусламж үзүүлж байгаа мэргэжлийн байгууллагуудын тоног төхөөрөмж, багаж аппаратын өнөөгийн байдлыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал бүрт тогтоох, үнэлгээ хийх	Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	ЭМЯ	2010	Мэргэжлийн байгууллагуудын материаллаг хэрэгцээг тодорхойлно.	Багаж тоног төхөөрөмжийн үнэлгээний тайлан	
7.2	Чих сонголын чиглэлийн багаж, тоног төхөөрөмж, технологийн зах зээлийн судалгааг гаргах	Мэргэжлийн зөвлөл,	ЭМЯ	2010-2011	Багаж, тоног төхөөрөмж, технологийн	Судалгааны тайлан	

					судалгаатай болно.	
7.3	Чих, сонгол шалгах үзлэгийн багажийн хангамжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх: а/ сум, өрхийн эмч нарыг чих, сонгол шалгах үзлэгийн багажаар хангах, б/дүүргийн эмнэлгүүд, БОЭТ-ийг чихний үзлэгийн бичил дурангаар хангах	ЭМЯ	СЯ, ДЭМБ, ГХЯ, НУБ-ын Хүүхдийн сан, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	2009-2012 2012-2015	Чих сонсголын тусламж үйлчилгээний чанар сайжирна.	Багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо, эзлэх хувь
Арга хэмжээ-8. Чих, сонсголын эмгэгийн оношлогоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж боловсруулж хэрэгжүүлэх, сургалт явуулах						
8.1	Сэргийлэх боломжтой дүлийрэлд хүргэдэг эмгэгүүд (дунд чихний хурц, архаг, шүүдэст, наалдаст үрэвсэл)-ийн оношлогоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамжийг боловсруулж мөрдүүлэх	ЭМЯ	СХЗГ Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	2010-2014-2018	Дүлийрэлд хүргэдэг эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээний чанар сайжирна	Батлагдсан стандарт
8.2	Чих, сонсголын анхан шатны тусламжийн талаар нярайн болон сум, өрхийн эмч нарт сургалт явуулах	Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	ЭМЯ ДЭМБ	2010-2014	Өрх, нярайн эмч нарын мэдлэг, дадал дээшилнэ	Сургалтын тайлан
8.3	Сонсголд нөлөөт эм, бэлдмэлийг зөвхөн мэргэжлийн эмчийн жорд бичигдсэн тун хэмжээний дагуу олгож хэвших, хяналттай хэрэглэх	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Мэргэжлийн	2009-2010	Сонсголд нөлөөт эм бэлдмэлийн хэт	Батлагдсан журам

талар журам гаргаж мөрдүүлэх	зөвлөл, нийгэмлэг Эм ханган нийлүүлэх байгууллага	хэрэглээнээс сэргийлнэ	хэрэглээнээс сэргийлнэ			
Арга хэмжээ-9. Сонсгол бууралттай ба дүлий хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах						
9.1	Сонсгол бууралттай ба дүлий хүмүүсийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалаар санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх	ЭМЯ	НХХЯ УНДЕГ	2010-2013	Эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах боломж нэмэгдэнэ	Батлагдсан шийдвэр/эрхзүйн баримт/
9.2	Дүлий, пайтан хүүхдэд зориулсан сургалтын талаар олон улсын туршлага судлуулах, орчин үеийн түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ авах	БСШУЯ	НХХЯ, ЭМЯ, ГХЯ	2011-2016	Сургалтын чанар дээшилнэ	Туршлага судалсан хүний тоо, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
9.3	Ядуу, амьдралын түвшин доогуур сонсгол бууралттай, дүлий хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах боломжийг судлах, одоогийн байдалд үнэлгээ хийх	ЭМЯ Мэргэж-лийн зөвлөл, нийгэмлэг	НХХЯ УХУГ	2010-2013	Нийгмийн халамжийн үйлчилгээний байдалд үнэлгээ хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тогтооно	Үнэлгээний тайлан
Арга хэмжээ-10. Сонсголын аппаратын хангамж, тохиргоо, засвар үйлчилгээг сайжруулах						
10.1	Чих, сонсголын тусламжийн чиглэлээр мэргэжилтэн (эмч, акустик инженер, лаборант, техникч) бэлтгэх, мэргэжлийг дээшлүүлэх	ЭМЯ	БСШУЯ ЭМШУИС ДЭМБ	2010-2019	Чих, сонсголын тусламжийн чанар сайжирна.	Сургалтад хамрагдсан тоо хүний
	Сонсголын аппаратын тохиргоо, засвар үйлчилгээний талаар	Мэргэж-лийн	ЭМЯ, ЭМШУИС	2010-2019	Сонсголын аппаратын	Сургалтад хамрагдсан хүний

10.2	сургалт явуулах	нийгэмлэг ЭМЖЖ	ДЭМБ		Тохиргоо, засвар сайжирна	тос
10.3	Техникийн өндөр үзүүлэлттэй дижитал сонголын аппаратын хангамжийг сайжруулахад чиглэсэн төсөл боловсруулж олон улсын байгууллага, хандивлагч орнуудад санал тавих	Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	ЭМЯ ДЭМБ НХХЯ	2010-2013	Сонголын аппаратын чанар, хангамж сайжирна.	Боловсруулсан төсөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
10.4	Улсын үйлчилгээний акустик болон отопластик лаборатори байгуулах	ЭМЯ	УКТЭ ЭНЭШТ	2010-2019	Сонгол бууралт, дүлийрэлтийг эрт оношлох, сонгол сэргээх хагалгааны үр дүнг хянах боломжтой болно	Байгуулагдсан лаборатори
10.5	Өөрийн орны онцлогт тохирсон оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн байнгын болон явуулын тусламжийг зохион байгуулах	ЭМЯ	ЭМШУИС, УКТЭ, ЭНЭШТ, Аймаг, Нийслэлийн ЭМГ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг	2010-2019	Тусламж үйлчилгээний хүртээмж сайжирна	Үйл ажиллагааны тайлан
Арга хэмжээ-11. Шуугиантай орчинд ажиллаж байгаа ажилчдын сонголыг хамгаалах арга хэмжээ авах						
	Үйлдвэрийн болон ахуйн шуугианы хүч, шуугианд өртөгсдийн тоо,	ЭМШУИС “ЭМЖЖ”	ЭМЯ НХХЯ	2010-2012	Баримт нотолгоонд	Судалгааны тайлан

11.1	сонсголын дундаж түвшинг тогтоох судалгаа хийх	Эмнэлэг Мэргэжлээс шалтгаалах өвчний үндэсний төв (МШӨҮТ)	ЭМЯ НХХЯ	ЭМЯ НХХЯ	2010-2013	Шуугианы гаралтай дүлийг хянах аргачлал гарч практикт нэвтэрсэн	Батлагдсан аргачлал, түүнийг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	тулгуурласан арга хэмжээ авна
11.2	Шуугианы гаралтай дүлийгээс сэргийлэх, хянах талаар аргачлал боловсруулж практикт нэвтрүүлэх	ЭМШУИС "ЭМЖЖ" Эмнэлэг МШӨҮТ	ЭМЯ НХХЯ	ЭМЯ НХХЯ	2010-2013	Шуугианы гаралтай дүлийг хянах аргачлал гарч практикт нэвтэрсэн	Батлагдсан аргачлал, түүнийг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	тулгуурласан арга хэмжээ авна
11.3	Дуу шуугианаас хэрэгслийн хангамжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	НХХЯ	СЯ, ГХЯ, ХХААХҮЯ	Ажил олгогч эздийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага	2010-2018	Аж ахуйн нэгж, байгууллагуудын дуу шуугианаас хамгаалах хэрэгслийн хангамж сайжирч сонсголд ээлтэй орчин бий болно.	Дуу шуугианаас хамгаалах хэрэгсэлтэй болсон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын тоо	тулгуурласан арга хэмжээ авна
Арга хэмжээ-12. Стратегийн хэрэгжилтэд хяналт тавих								
12.1.	Стратегийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээ авах	МХЕГ	ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ	ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ	2010-2019	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг тогтоож шаардлагатай	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	тулгуурласан арга хэмжээ авна

12.2	Стратегийн хэрэгжилтийн явцын байдалд хяналт-шинжилгээ хийх (3-4 аймаг, дүүрэгт)	ЭМЯ НХХЯ	МХЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ХХҮГ	Жил бүр	арга хэмжээ авсан байна Стратегийн хэрэгжилтийн явцын талаар хяналт- шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг тодорхойлоно	Хяналт-шинжилгээ хийсэн аймаг, дүүргийн тоо, тэдгээрийн тайлан
12.3	Стратегийн хэрэгжилтийн байдалд дунд хугацааны болон эцсийн үнэлгээ хийх	ЭМЯ НХХЯ	МХЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ХХҮГ	2014 2019	Стратегийн хэрэгжилтийн байдалд дунд хугацааны болон эцсийн үнэлгээ хийж цаашид авах арга хэмжээг тодорхойлоно	Үнэлгээний тайлан